

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 01

Зуунмод

ТӨВ АЙМГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ ДҮГНЭСЭН ТУХАЙ

2022.01.24

Зуунмод

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго:

“Төв аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний жилийн эцсийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үнэлэх, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн түвшингээр тодорхойлж үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдсэн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж гаргах

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй:

Засгийн газрын 2022 оны 206 дугаар тогтоол болон аймгийн Засаг даргын 2022 оны 300 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу ирүүлсэн тайлан мэдээ, холбогдох нотлох баримтад тулгуурлан гүйцэтгэлд үнэлгээ өгөх

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын явцад тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг зохион байгуулах

Гурав. Төв аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт:

1. Ковид – 19” цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын 3 зорилт 9 арга хэмжээ 98.15%
2. Хүний хөгжлийн бодлогын 19 зорилт 69 хэрэгжүүлэх арга хэмжээ 91.55%
3. Эдийн засгийн бодлогын 2 зорилт 10 хэрэгжүүлэх арга хэмжээ 95.23%
4. Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн бодлогын 3 зорилт 38 арга хэмжээ 88.32%
5. Ногоон хөгжлийн бодлогын 5 зорилт 26 арга хэмжээ 89.76%
6. Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын 8 зорилт 48 арга хэмжээ 85.42%
7. Засаглалын бодлогын 11 зорилт 55 арга хэмжээ 88.37%
8. Аймаг, сум, нийгэм, эдийн засгийн салбар үүсч байгуулагдсаны түүхт ой угтсан бүтээлч ажлын 1 зорилт 2 арга хэмжээ 78.36%, нийт 52 зорилт 257 хэрэгжүүлэх арга хэмжээний дундаж үнэлгээ 89.4 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

Дөрөв. Төв аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт:

Засгийн газрын 2022 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2 дахь хэсэгт заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйн дагуу хяналт-шинжилгээ, хийж урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, зарим арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулав. Үүнд:

1. “Урьдчилан сэргийлэх үзлэгийг иргэн бүрт III аяныг хэрэгжүүлнэ” гэсэн 10 дахь арга хэмжээ 2022 оны зорилтод түвшиндээ бүрэн хүрээгүй тул 85.37 хувийг 50% болгон үнэлгээг бууруулав.

2. “Хавдрын эсрэг “Эрүүл Төв аймаг” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ” гэсэн 14 дахь арга хэмжээ хавдрын нийт өвчлөлийн эрт үеийн илрүүлэг зорилтот түвшиндээ хүрээгүй тул 90.32 хувийг 70% болгон үнэлгээ бууруулав.

3. “Ажилгүй иргэдэд АМЧБОлгож, зөвлөгөө мэдээлэл өгч хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнүүдэд хамруулан хөдөлмөр эрхлэх ур чадварыг нэмэгдүүлнэ” гэсэн 61 дэх арга хэмжээг 95.79% болгон үнэлгээ өсгөв.

4. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Загвар төв”-өөр дамжуулан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ” гэсэн 62 дахь арга хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор жилд аймагт 1 төслийг шалгаруулан 10,0 сая төгрөгийг эргэн төлөлтгүйгээр олгохоор шийдвэрлэж “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт” өөрчлөлт орсон байна. 2022 оны “Старт-Ап”-шалгаруулж, 10.0 сая төгрөг олгосон тул 90.5 хувийг 100% болгон үнэлгээ өсгөв.

5. “Халамжаас хөдөлмөрт шилжүүлэх зорилтын хүрээнд халамжийн хөтөлбөрүүдийг хөдөлмөр эрхлэлтэй уялдуулах замаар халамж хүртэгч иргэдийн идэвх, сонголтод тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ” гэсэн 63 дахь арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн тул 90.0 хувийг 100% болгон үнэлгээ өсгөв.

6. “Соёл, урлагийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ” гэсэн 67 дахь арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн тул 90.0 хувийг 100% болгон үнэлгээ өсгөв.

7. “Соёл, урлагийн байгууллагуудын материалаг бааз, тоног төхөөрөмж хангалтыг нэмэгдүүлнэ” гэсэн 68 дахь заалт 2022 онд 72.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар материаллаг баазыг нэмэгдүүлсэн тул тоо баримтаа задаргаатай цогц байдлаар тайлагнавал үнэлгээ өсөх боломжтой гэж үзэж байна.

8. “Аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ой угтсан ажлын хүрээнд “Авьяас бидний бахархал” сэдэвт 1000 ардын авьяастан, мэргэжлийн уран бүтээлчдийн урлагийн тоглолтын бэлтгэл хангана” гэсэн 70 дахь арга хэмжээ 27 сумын хэмжээнд ардын авьяастны тоо судалгааг нэмж цогц байдлаар тайлагнавал үнэлгээ өсөх боломжтой гэж үзэж байна.

9. “Учиртай гурван толгой” үндэсний сонгодог дуурийн “Шилдэг дүр” шалгаруулах VIII, “Ардын богино дуу дуулаач”-дын улсын VII уралдаануудыг зохион байгуулна гэсэн 71 дахь арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж 70.0 хувь гэснийг 90.0 хувь болгон үнэлгээ өсгөв.

10. “Орон нутгийн өмчит компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьж, үр ашигтай ажиллуулахад мэргэжлийн удирдлага зохицуулалтаар хангаж, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлнэ” гэсэн 85 дахь арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж 70.0 хувийг 100.0% болгон үнэлгээ өсгөв.

11. “Орон нутагт ажиллах хөдөө аж ахуйн мэргэжилтнийг тэтгэлэгт хөтөлбөрөөр бэлтгэн, хүний нөөцийг чадавхжуулан, малчдын залгамж халааг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ” гэсэн 108 дахь заалтын хувьд Эдийн засгийн чуулган, Малчдын зөвлөгөөн, Тариаланчдын зөвлөгөөн, Хоршоологчдын зөвлөгөөн гэх мэт олон ажлуудад хөдөө аж ахуйн мэргэжилтэн хамрагдаж чадавхжсан тул хэрэгжилтийг цогц байдлаар тоо баримт, судалгаа мэдээлэлтэй тайлагнавал үнэлгээ өсөх боломжтой гэж үзэж байна.

12. “Мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг мөрдөн мөшгөх, мал эмнэлгийн цахим гэрчилгээ нэвтрүүлж, ажил үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хэрэгжүүлж байгаа мал эмнэлгийн байгууллагын ажлын үр дүнг баталгаажуулна” гэсэн 113 дахь заалт зорилтод түвшиндээ хүрээгүй учир 64.46 хувийг 0 болгон үнэлгээ бууруулав

13. “Тусгай сангуудын зээлийн зориулалт, ашиглалтад хөндлөнгийн хяналт хийж, үр ашгийг нэмэгдүүлнэ” гэсэн 124 дахь заалтыг зорилт арга хэмжээний дагуу үнэлж 50.0 хувийг 70.0 % болгон үнэлгээ өсгөв.

14. “Стандарт хангасан хүнс барааны зах, супермаркет, зоогийн газар, зочид буудал, ахуйн үйлчилгээ байгуулах үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ” гэсэн 126 дахь заалт зорилтод түвшиндээ бүрэн хүрсэн тул үнэлгээг 100 хувь болгон өсгөв.

15. “Төрөөс ойн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлнэ” гэсэн 127 дахь заалтыг шалгуур үзүүлэлтийн дагуу цогц байдлаар тайлагнавал үнэлгээ өсөх боломжтой гэж үзэж байна.

16. “Ойг нөхөн сэргээх, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг нэмэгдүүлнэ” гэсэн 128 дахь заалтыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж 94.92 хувийг 70.93% болгон үнэлгээ бууруулав.

17. “Аялал жуулчлалын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна” гэсэн 148 дахь арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж 50.0 хувийг 70.0% болгон үнэлгээ өсгөв.

18. “Ашиглагдаж буй барилга байгууламжийг паспортжуулан, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийж, хүчитгэлийн зураг боловсруулах ажлыг эхлүүлнэ” гэсэн 173 дахь заалтыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж 30.0 хувийг 100 хувь болгон үнэлгээ өсгөв.

19. “Аймгийн төв /орон нутгийн зэрэглэлтэй хот/ сумын төв, бусад суурин газрын газар ашиглалтын байдалд судалгаа хийж, суурин газрын тэг гортигийг сумдын ИТХ-аар шинэчлэн тогтоож газрын мэдээллийн системд бүртгэнэ” гэсэн 198 дахь арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж 70.0 хувийг 90.0% болгон үнэлгээ өсгөв.

20. “Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэнтэй холбогдуулан техник хэрэгслээр хангана” гэсэн 223 дахь заалтын хувьд аймгийн Засаг даргын Тамгын газар нөөц боломждоо тулгуурлан сонгон шалгаруулалтын ажил хэвийн явагдаж байгаа тул 50.0 хувийг 70.0% болгон үнэлгээ өсгөв.

21. “Төрийн архивын байрны зураг төсвийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлнэ” гэсэн 241 дэх арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж 90.0 хувийг 70.0% болгон үнэлгээ бууруулав

Төв аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний 52 зорилт, 257 арга хэмжээний дундаж үнэлгээг 90.25 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэлээ.

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмж, цаашид анхаарах асуудлууд:

1. Төсөв, хөрөнгийн асуудлаас шалтгаалж удаашралтай хэрэгжиж байгаа ажил, арга хэмжээг эрчимжүүлэх тал дээр анхаарч ажиллах, шаардлагатай бол дараа оны төсөвт тусгуулах саналаа холбогдох газарт уламжлах, тухайн ажил арга хэмжээг эрчимжүүлж ажиллах

2. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамралтыг хувийг нэмэгдүүлж, 2023 оны зорилтот түвшинд хүрч ажиллах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг тасралтгүй зохион байгуулах

3. 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтад ахуйн осол гэмтлийн шалтгаант нас баралтын эзлэх хувийг бууруулах тал дээр тодорхой арга хэмжээ авч ажиллах

4. Сөүл хотын их сургуулийн салбарыг Зуунмод суманд байгуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх

5. Сумдын соёлын төвийн үйл ажиллагаанд чанар, үр дүнгийн үнэлгээ тогтоож “Шилдэг үйл ажиллагаатай соёлын төвийг” шалгаруулах ажлыг ойрын хугацаанд зохион байгуулах

6. Монгол малын махны ач тусыг сурталчлан таниулж, мал бордох, үр ашигтай технологи нэвтрүүлэн, махны экспортыг нэмэгдүүлэн тухайн оны зорилтод түвшиндээ бүрэн хүрч ажиллах тал дээр зохион байгуулалтын арга хэмжээ авах

7. Нийтийн зорчигч тээврийн болон такси үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх

8. Туул голын хойд болон дунд салаан дээрх төмөр бетон гүүрийг шинэчлэх

9. Зарим сумдын чиглэлд хот хоорондын болон орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээ нэвтрүүлэх ажлын түргэн шуурхай зохион байгуулах

10. Өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй сумдыг холбох ажлыг эрчимжүүлэх, төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэх

11. “Цахим-Төв аймаг” төслийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлж, үр дүнд хүргэх

12. Зам тээврийн осол, зөрчлийг бууруулах урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх

13.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог хангаж олон нийтийн цагдаа ажиллуулж хамтран ажиллах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах

14.Гадаад харилцааг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах ажлыг эрчимжүүлэх

15.Аймаг, сум, нийгэм, эдийн засгийн зарим салбар байгуулагдсаны түүхт ой угтсан бүтээлч ажлуудыг эрчимжүүлж, үр дүнд хүргэх

16. Засгийн газрын 2022 оны 206 дугаар тогтоол болон аймгийн Засаг даргын 2022 оны 300 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан нийтлэг болон тусгай шаардлагын дагуу тайлагнах, журмын 6.2 дахь хэсэгт заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйгээр үнэлэх

17.Хэлтэс, агентлаг, харьяа байгууллагууд зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн дагуу тухайн арга хэмжээний үр дүнг бүрэн илэрхийлэхүйц тоо мэдээ, тооцоо судалгаатай, цогц байдлаар тайлагнах

18.Бодлогын баримт бичиг төлөвлөх болон тайлагнахдаа ажлын 3-5 хоногийн өмнө хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс дүгнэлт авах

19.Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангасан тайлан ирүүлэх, үг үсэг, утга найруулгын алдааг хянаж тайлан мэдээг ирүүлэх

ТАНИЛЦСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ХУЯГБААТАР

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.БАДАМСҮРЭН

